Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

**БАНКНЫ ТУХАЙ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн дараах зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй.

1/4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"4.2.Банк нь нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байна."

2/27 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"27.5.Монголбанк доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь бүрдсэн тохиолдолд банк төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болох гарцаагүй нөхцөл байдал үүссэнд тооцно:

27.5.1.банк хадгаламж эзэмшигч, харилцагч, бусад үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн мөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болсон; эсхүл гаргаж өгөх боломжгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон;

27.5.2.зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүйгээс цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

27.5.3.банкны пассив нь активаасаа хэтэрсэн, эсхүл ердийн боломжит хугацаанд хэтрэх нь хяналт шалгалтаар тогтоогдсон.

27.5.4.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний шаардлагыг биелүүлээгүй."

3/34 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"34.4.Банкны эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ."

4/ 38 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"38.5.Банк холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагагаас тогтоосон мэдээллийг нийтэд мэдээлнэ."

5/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 20 дахь заалт:

"3.1.20.банкны системд нөлөө бүхий банк" гэж олон улсын жишигт нийцүүлэн Монголбанкнаас системийн нөлөөтэй гэж тогтоосон банкийг."

6/43 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 13 дахь заалт:

"43.2.13.Шаардлагатай тохиолдолд мэргэшсэн бусад этгээдтэй хамтран банкинд шалгалт хийх."

7/48 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 17 дахь заалт:

"48.1.17.Энэ хуулийн 27 дугаар зүйлд зүйлд заасан үндэслэлээр банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох."

8/52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"52.1.3.шаардлагатай тохиолдолд банкны хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг түдгэлзүүлэх."

9/52 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8-9 дэх заалт:

"52.2.8.Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;

52.2.9.Хуульд нийцсэн бусад."

2 дугаар зүйл. Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн гарчигийн "төрөл" гэсний дараа ", хэлбэр" гэж, 17.8 дахь хэсгийн "хувьцаа эзэмшигчид" гэсний өмнө "нөлөө бүхий" гэж, 20.4 дэх хэсгийн "зөвшөөрөл олгох" гэсний дараа ", банкны хувьцаа эзэмших хязгаарлалтыг тооцох" гэж, 30.3 дахь хэсгийн "бүрэн эрхт төлөөлөгчийн" гэсний дараа "оролцоо", "саналаар" гэсний дараа "хурал, хурлын шийдвэр" гэж, 35.2 дахь хэсгийн "төлбөрийн чадвар," гэсний дараа "банкны систем дэх нөлөө" гэж, 35.4 дэх хэсгийн "зээл төлөгдөхөд" гэсний өмнө "активын эрсдэл" гэж, 53.1 дэх хэсгийн "журмын дагуу" гэсний дараа "банкны системийн нөлөө бүхий" гэж, 68.2 дахь хэсгийн "банкийг" гэсний дараа "албадан" гэж, 3.1.12 дахь заалтын "хувьцаа эзэмшигчийг" гэсний дараа "банкны хувьцааны эцсийн өмчлөгчийн эрхийг шууд бусаар хэрэгжүүлдэг этгээдийг;" гэж, 3.1.16 дахь заалтын "хяналт шалгалтаар" гэсний дараа "банкны зохистой засаглал алдагдсан буюу" гэж, 6.1.12 дахь заалтын "ажил, үйлчилгээ" гэсний дараа ", энэ хуульд заасан үйл ажиллагааг эрхлэхэд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа." гэж, 16.1.2 дахь заалтын "өөрийн хөрөнгийн хүрэлцээ" гэсний өмнө "хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ" гэж, "зээл төлөгдөхөд" гэсний өмнө "активын эрсдэл" гэж, "гадаад валютын" гэсний өмнө "эх үүсвэрийн төвлөрөл," гэж, 32.1.2 дахь заалтын "гэмт хэрэгт" гэсний өмнө "эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг" гэж, 33.3.3 дахь хэсгийн "таван жилийн хугацаанд" гэсний дараа "төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс бусад" гэж, 69.1.4 дэх заалтын "зээл авах" гэсний өмнө "банкны хөрөнгө үйл ажиллагааны зардлыг гаргахад хүрэлцэхгүй тохиолдолд" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Банкны тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/36 дугаар зүйл:

"36 дугаар зүйл.Банкны хувьцааг эзэмших зөвшөөрөл олгох

36.1.Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны хорин хувиас хэтрэхгүй байна.

36.2.Энэ хуулийн 36.1 дэх хэсэгт заасан хязгаарлалт нь дараах тохиолдолд хамаарахгүй:

36.2.1.Засгийн газраас үүсгэн байгуулсан банк болон 58 дугаар зүйлд заасны дагуу байгуулсан тусгай зориулалтын банк;

36.2.2.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд заасны дагуу төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банкны төрийн эзэмшлийн хувьд;

36.3.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт орох, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах болон өөрийн хөрөнгийн хэмжээг өөрчлөх аливаа хэлцэл хийх бол банк энэ талаар тухай бүр нь Монголбанкинд бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

36.4.Аливаа этгээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орсон бол банк нь Монголбанкинд ажлын 10 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

36.5.Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох хуулийн этгээдийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орсон бол Монголбанкинд ажлын 10 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

36.6.Монголбанк банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орох, хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нэмж гаргах зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч, энэ хуулийн 19, 20 дугаар зүйл, 23.1 дахь хэсэг, энэ зүйлд заасан шаардлага, шалгуурыг хангасан, баримт бичиг бүрэн гүйцэд бүрдсэнээс хойш 60 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэр гаргаж энэ талаар банкинд мэдэгдэнэ.

36.7.Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахыг Монголбанк зөвшөөрөөгүй, эсхүл энэ хуульд заасан шаардлага, шалгуурыг хангаагүй бол тухайн хувьцаа нь саналын эрхгүй, ногдол ашиг авах эрхгүй бөгөөд зөвшөөрөгдөөгүй хэмжээгээр банкны өөрийн хөрөнгөөс хасч тооцож, бусдад худалдах буюу шилжүүлнэ.

36.8.Энэ зүйл нь мөн хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан банк байгуулах, банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас эзэмших иргэн, хуулийн этгээд, тэдгээрийн холбогдох этгээдэд нэгэн адил хамаарна.

36.9.Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь банкны хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн талаархи дэлгэрэнгүй мэдээг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу ирүүлнэ.

36.10.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, шинээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, хувьцаагаа нийтэд санал болгох, худалдах, шилжүүлэх, үүнтэй төстэй бусад хэлцэл хийх журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална.

36.11.Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг банкинд буцаан худалдахыг хориглоно.

36.12.Иргэн, хуулийн этгээд бусдын нэрийг ашиглан банкны хувьцааг шууд бус хэлбэрээр эзэмшихийг хориглоно.

36.13.Энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан банкны хувьцааг Монголбанк зөвшөөрснөөс бусад этгээдэд худалдахыг хориглоно.

36.14.Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.

36.15.Банкны гаргасан хувьцааг худалдан авах хөрөнгө нь мөнгөн хөрөнгө байх бөгөөд энэ хуульд заасны дагуу өр төлбөр, хоёрдогч өглөг, хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг хувьцаанд хөрвүүлэхэд энэ шаардлага хамаарахгүй.

36.16.Банк нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны эцсийн өмчлөгчийг тодорхойлсон мэдээлэл, холбогдох баримт бичгийг Монголбанкинд ирүүлэх бөгөөд эцсийн өмчлөгч өөрчлөгдөх бүрт уг мэдээллийг шинэчилж ирүүлнэ.

36.17.Монголбанк банкны хувьцааны эцсийн өмчлөгчийн мэдээллийг шалгасны үндсэн дээр энэ хуулийн 36.3 дахь хэсэгт зааснаар зөвшөөрөл авах этгээдийг тогтоож банкинд мэдэгдэнэ.

36.18.Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч дараахь шалгуурыг хангасан байна:

36.18.1.тухайн этгээд нь дампуурлын хэргийн хариуцагч, эсхүл хариуцагч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бус байх;

36.18.2.эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаагүй;

36.18.3.санхүүгийн чадавхтай байх;

36.18.4.нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн банкны нэгдэл нь Монголбанкнаас хяналт шалгалт хийх боломж бүхий бүтэцтэй байх;

36.18.5.тухайн хувьцааны эцсийн өмчлөгчийг хангалттай нотолсон байх;

36.18.6.өөрөө, эсвэл нэгдмэл сонирхолтой этгээд, эцсийн өмчлөгч нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн биш байх эсвэл төрийн өндөр албан тушаалд хамаарах улс төрийн албан тушаалтан биш байх."

2/73 дугаар зүйл:

"73 дугаар зүйл.Төлбөр барагдуулах дараалал

73.1.Банкны хөрөнгийг худалдан борлуулсан, захиран зарцуулсан, төлөгдсөн орлогоос Монголбанкнаас тогтоосон журмаар тодорхойлсон үүргийн гүйцэтгэл хангах аргаар баталгаажснаас бусад төлбөрийн нэхэмжлэлийн шаардлагыг хангахад доор дурдсан дараалыг баримтална:

73.1.1.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн банкнаас гаргуулж байсан төлбөр;

73.1.2.Монголбанкны болон эрх хүлээн авагчийн үйл ажиллагааны зардал;

73.1.3.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан нөхөн төлбөр төлөх даатгагдсан хадгаламж

73.1.4.иргэдийн энэ хуулийн 73.1.3-т зааснаас бусад хадгаламжийн төлбөр;

73.1.5.хуулийн этгээдийн энэ хуулийн 73.1.3-т зааснаас бусад хадгаламжийн төлбөр;

73.1.6.банкны эрх бүхий албан тушаалтнаас бусад ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй цалин хөлс;

73.1.7.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасны дагуу даатгагдсан хадгаламж эзэмшигчийн шаардах эрхийг шилжүүлсэн авсан Хадгаламжийн даатгалын корпорацийн шаардлага;

73.1.8.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 7.2.1-7.2.3-т заасан хадгаламжийн даатгалд хамаарахгүй хадгаламжийн төлбөр

73.1.9. Засгийн газарт төлөх өр төлбөр, албан татвар;

73.1.10 Монголбанкны шаардах эрх бүхий төлбөрийн шаардлага;

73.1.11.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 7.2.4-7.2.6-д заасан хадгаламжийн даатгалд хамаарахгүй хадгаламжийн төлбөр;

73.1.12.холбогдох зээл, өрийн хэрэгсэлийн гэрээнд банкны бусад өр төлбөрийн дараалаас дээгүүр байхаар заасан зээл, түүнтэй адилтгах өр төлбөр;

73.1.13.үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар баталгаажаагүй бусад өр төлбөр;

73.1.14.хоёрдогч өглөг;

73.1.15.банкны хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хамаарах үнэт цаас, банкны нийт гаргасан энгийн хувьцааны таваас дээшгүй хувийн хувьцаа эзэмшигчийн хувьцааны төлбөр

73.1.16.Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хамаарах үнэт цаас болон 73.1.14-д зааснаас бусад хувьцаа эзэмшигчийн хувьцааны төлбөр."

3/31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"31.2.Банкны төлөөлөн удирдах зөвлөл ес ба түүнээс дээш гишүүнтэй байна."

4/32 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"32.3.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгосон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр Монголбанкны зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно."

5/33 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"33.1.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна."

6/54 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"54.3.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Монголбанк банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохгүй байж болно."

7/67 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"67.2.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авсан банкны өөрийн хөрөнгө энэ хууль, Монголбанкнаас гаргасан журамд заасан хэмжээнд хүрч нэмэгдсэн тохиолдолд Монголбанк бүтцийн өөрчлөлтийн авах арга хэмжээг дуусгавар болгож, банк байгуулах зөвшөөрлийг олгоно."

8/27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

"27.1.2.Банк төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болох гарцаагүй нөхцөл байдал үүссэн тухай Монголбанкны шийдвэр гарсан;"

9/43 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт:

"43.2.1.банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг тогтоож, хангуулах;"

10/48 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

"48.1.8.банкны актив, өр төлбөрийн хэмжээ, өөрчлөлтийг хязгаарлах, эсхүл активыг төрөлжүүлэхийг даалгах;"

11/69 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт:

"69.1.13.банкны актив, пассивын үнэлгээг хараат бус, хөндлөнгийн, мэргэжлийн этгээдээр зохих стандарт, шаардлагын дагуу хийлгэх;"

12/Банкны тухай хуулийн 41.3 дахь хэсгийн "хувьцаат компани болох банкны хувьд" гэснийг "банк" гэж, 47.7 дахь хэсгийн "батлуулах" гэснийг "батлах" гэж, 54.1 дэх хэсгийн "үндэслэлээр" гэснийг "үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд" гэж, 54.4 дэх хэсгийн "Сангийн яаманд" гэснийг "Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдэд" гэж, 56.7 дахь хэсгийн "хийлгэнэ" гэснийг "хийлгэж болно" гэж, 63.1 дэх хэсгийн "хураамжаас" гэснийг "хураамж, бусад хөрөнгө оруулалтаас" гэж, 75.1 дэх хэсгийн "Монголбанкны" гэснийг "Монголбанк, эрх бүхий бусад этгээдийн" гэж, 75.1 болон 75.2 дахь хэсгийн "гомдол" гэснийг "нэхэмжлэл" гэж, 3.1.12 дахь заалтын "эзэмшигчийг" гэснийг "эзэмшигч" гэж, 3.1.17 дахь заалтын "өмчлөгч этгээдийг" гэснийг "өмчлөгч хүнийг" гэж, 16.1.2 дахь заалтын "журмын" гэснийг "журам, шийдвэрийн" гэж, 24.1.5 дахь заалтын "этгээд" гэснийг "20 хүртэл тооны хувьцаа эзэмшигч" гэж, 29.2.8 дахь хэсгийн "мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр" гэснийг "зөвшөөрөлтэйгээр" гэж,

31.3.2 дахь заалтын "Ерөнхийлөгчтэй зөвшилцөн" гэснийг "зөвшөөрснөөр" гэж, 31.4.2 дахь хэсгийн "банкны эрх ашгийг" гэснийг "банк, банкны харилцагчийн эрх ашгийг" гэж, 52.2.2 дахь заалтын "бүрмөсөн" гэснийг "бүхэлд нь" гэж, 68.1.1 дэх заалтын "энэ хуульд заасан" гэснийг "энэ хуулийн 53.1-т зааснаас бусад" гэж, "цуцалсан" гэснийг "хүчингүй болгосон" гэж тус тус өөрчлөх.

4 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 4.1 дэх хэсгийн "үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хязгаарлагдмал хариуцлагатай, хувьцаат;" гэснийг, 29.1 дэх хэсгийн "нэг хувьцаа эзэмшигчтэй банкны хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө," гэснийг, 43.2 дахь хэсгийн "арга хэмжээ авахыг банкнаас шаардах" гэснийг, 16.1.4 дэх заалтын "харилцах" гэснийг, 52.1.2 дахь заалтын ", сайжруулах" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Банкны тухай хуулийн 36[1] дүгээр зүйл, 19.1.5 дахь заалт, 54.1.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ